



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 29 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/42/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Д.Зэндмэнэ
Утас: 261628 Цахим хаяг: zendmened@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк ОМ Аудит ХХК
Захирал: Б.Жаргалсайхан
Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2Төлбөрийн акт	19
4.3Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 29 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.УНДРАЛ ТАНАА

2022.02.24 № 07/335
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 136.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Үнэн зөв байдал”, “Толилуулга ба тодруулга”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>91 747 076,96</u>	<u>118 479 443,24</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	91 747 076,96	118 479 443,24
351	Түүхий эд материал	13 899 735,15	8 995 201,01
35130	Эм боох материал	13 899 735,15	8 995 201,01
354	Хангамжийн материал	77 847 341,81	109 484 242,23
35410	Бичиг хэргийн материал	1 671 350,00	443 850,00
35420	Аж ахуйн материал	4 248 665,00	2 288 693,77
35440	Түлш, шатах тослох материал	3 276 800,00	849 688,01
35450	Барилгын засварын материал	1 451 500,00	4 897 605,00
35460	Хүнсний материал	261 900,00	3 639 144,98
35470	Бусад хангамжийн материал	66 937 126,81	97 365 260,47
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4 726 755 197,17</u>	<u>4 678 927 407,80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4 726 755 197,17	4 678 927 407,80
392	Биет хөрөнгө	4 181 290 877,17	4 133 463 087,80
39201	Барилга, байгууламж, орон сууц	4 082 676 048,00	4 082 676 048,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(276 103 240,08)	(379 185 060,12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126 974 891,00	126 974 891,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49 379 625,20)	(54 074 828,27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	553 330 634,22	649 525 144,22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(438 832 441,48)	(487 024 415,30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	178 024 932,47	197 467 489,27
39208	Хуримтлагдсан элэгдэл	(147 513 955,73)	(159 753 126,25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	219 362 587,40	219 362 587,40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(87 873 970,88)	(88 567 463,60)
39217	Ном	20 625 017,45	26 061 821,45
393	Биет бус хөрөнгө	545 464 320,00	545 464 320,00
39301	Програм хангамж	1 540 000,00	1 540 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1 540 000,00)	(1 540 000,00)
39303	Бусад биет бус хөрөнгө	545 464 320,00	545 464 320,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4 818 502 274,13</u>	<u>4 797 406 851,04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>5 444 986,39</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5 444 986,39
413	Өглөг	-	5 444 986,39
4136	Бусад өглөг	-	5 444 986,39
41361	Байгууллагад төлөх өглөг	-	5 444 986,39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4 818 502 274,13</u>	<u>4 791 961 864,65</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4 818 502 274,13	4 791 961 864,65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2 767 655 847,77	2 767 655 847,77
512	Хуримтлагдсан үр дүн	(986 718 149,98)	(1 013 258 559,46)
51210	Өмнөх үеийн үр дүн	(986 718 149,98)	(986 718 149,98)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(26 540 409,48)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3 037 564 576,34	3 037 564 576,34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4 818 502 274,13</u>	<u>4 797 406 851,04</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3 134 538 670,91	3 347 548 244,40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147 881 470,91	131 174 677,40
120	Нийтлэг татварын бус орлого	-	130 174 677,40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1 480 950,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1 480 950,00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан /Үндсэн хөрөнгө/		109 650 620,80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан /Бараа материал/		19 043 106,60
122	Тусламжийн орлого	147 881 470,91	
122001	Хандив тусламж /дотоод/	147 881 470,91	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2 986 657 200,00	3 217 373 567,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2 983 959 600,00	3 214 238 200,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2 983 959 600,00	3 214 238 200,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2 697 600,00	3 135 367,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	625 000,00	835 367,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2 072 600,00	2 300 000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3 144 654 020,39	3 374 088 653,88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3 144 654 020,39	3 374 088 653,88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 686 447 267,06	2 906 175 798,17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2 031 724 728,51	2 246 595 046,70
210101	Үндсэн цалин	1 531 073 205,51	1 749 095 549,70
210102	Нэмэгдэл	418 881 157,00	497 499 497,00
210104	Урамшуулал	81 770 366,00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	269 917 657,87	243 186 807,95
210201	Тэтгэврийн даатгал	194 646 763,95	167 090 073,57
210202	Тэтгэмжийн даатгал	20 768 509,04	20 995 495,94
210203	ҮОМШӨ-ний даатгал	15 485 424,80	16 632 227,26
210204	Ажилгүйдлийн даатгал	5 401 541,10	3 482 324,06
210205	Эрүүл мэндийн даатгал	33 615 418,98	34 986 687,12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86 029 440,29	116 305 756,39
210301	Гэрэл, цахилгаан	20 009 267,00	17 797 870,80
210302	Түлш, халаалт	46 744 108,29	52 911 771,59
210303	Цэвэр, бохир ус	19 276 065,00	45 596 114,00
2104	Хангамж, бараа материалын зардал	34 078 052,00	46 434 883,87
210401	Бичиг хэрэг	5 051 075,00	6 989 655,65
210402	Тээвэр, шатахуун	7 470 220,00	4 700 611,99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 631 320,00	3 137 850,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2 628 720,00	4 385 200,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15 296 717,00	27 221 566,23

2105	Нормативт зардал	54 794 715,50	31 663 235,09
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6 451 915,50	7 227 474,14
210502	Хоол, хүнс	48 342 800,00	14 064 260,95
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	10 371 500,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20 350 850,00	13 332 141,00
210604	Урсгал засвар	20 350 850,00	13 332 141,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18 868 670,00	26 050 080,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17 239 400,00	22 998 230,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1 000 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	278 820,00	321 700,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	484 200,00	194 500,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	87 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	866 250,00	1 448 650,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	170 683 152,89	182 607 847,17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3 501 600,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 088 000,00	10 204 587,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	169 595 152,89	168 901 660,17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	458 206 753,33	467 912 855,71
2132	Бусад урсгал шилжүүлэг	163 298 100,00	246 311 740,14
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	25 549 728,36
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	162 698 100,00	216 785 700,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600 000,00	3 976 311,78
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	294 908 653,33	221 601 115,57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)= (1)-(2)	(10 115 349,48)	(26 540 409,48)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(10 115 349,48)	(26 540 409,48)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 767 655 847,77	3 037 564 576,34	(976 602 800,50)	4 828 617 623,61
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2 767 655 847,77	3 037 564 576,34	(976 602 800,50)	828 617 623,61
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(10 115 349,48)	(10 115 349,48)
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 767 655 847,77	3 037 564 576,34	(986 718 149,98)	4 818 502 274,13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2 767 655 847,77	3 037 564 576,34	(986 718 149,98)	4 818 502 274,13
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(26 540 409,48)	(26 540 409,48)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 767 655 847,77	3 037 564 576,34	(1 013 258 559,46)	4 791 961 864,65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2 987 581 767,00</u>	<u>3 217 373 567,00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	924 567,00	835 367,00
120	Нийтлэг татварын бус орлого	924 567,00	835 367,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	924 567,00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	924 567,00	
120009	Бусад орлого		835 367,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2 986 657 200,00	3 216 538 200,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2 983 959 600,00	3 214 238 200,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2 983 959 600,00	3 214 238 200,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2 697 600,00	2 300 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	625 000,00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2 072 600,00	2 300 000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2 983 126 867,00</u>	<u>3 207 431 267,00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 983 126 867,00	3 207 431 267,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 501 535 733,67	2 733 180 423,43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2 050 708 707,64	2 209 621 887,32
210101	Үндсэн цалин	1 110 822 043,79	1 261 005 630,32
210102	Нэмэгдэл	835 034 451,85	948 616 257,00
210104	Урамшуулал	104 852 212,00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	250 933 678,74	280 255 079,11
210201	Тэтгэврийн даатгал	177 598 103,40	200 804 599,10
210202	Тэтгэмжийн даатгал	18 768 396,86	22 129 379,38
210203	ҮОМШӨ-ний даатгал	13 157 894,35	17 378 052,35
210204	Ажилгүйдлийн даатгал	3 171 423,14	3 616 327,78
210205	Эрүүл мэндийн даатгал	38 237 860,99	36 326 720,50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86 029 440,29	110 115 600,00
210301	Гэрэл, цахилгаан	20 009 267,00	17 797 870,80
210302	Түлш, халаалт	46 744 108,29	46 721 615,20
210303	Цэвэр, бохир ус	19 276 065,00	45 596 114,00
2104	Хангамж, бараа материалын зардал	31 443 987,00	31 289 647,00
210401	Бичиг хэрэг	4 530 595,00	4 162 000,00
210402	Тээвэр, шатахуун	5 149 800,00	2 273 500,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 595 320,00	3 137 850,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3 528 720,00	4 940 567,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14 639 552,00	16 775 730,00

2105	Нормативт зардал	32 838 500,00	28 254 534,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4 702 070,00	6 169 960,00
210502	Хоол, хүнс	21 870 630,00	16 925 174,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6 265 800,00	5 159 400,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17 962 700,00	15 360 186,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	813 000,00	2 380 700,00
210604	Урсгал засвар	17 149 700,00	12 979 486,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26 935 870,00	40 566 150,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25 306 600,00	37 514 300,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1 000 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	278 820,00	321 700,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	484 200,00	194 500,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		87 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	866 250,00	1 448 650,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4 682 850,00	17 717 340,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		7 423 600,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4 682 850,00	10 293 740,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	481 591 133,33	474 250 843,57
2132	Бусад урсгал шилжүүлэг	186 682 480,00	252 649 728,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23 384 380,00	31 982 828,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	162 698 100,00	216 785 700,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600 000,00	3 881 200,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	294 908 653,33	221 601 115,57
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	294 763 153,33	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		219 301 115,57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4 454 900,00</u>	<u>9 942 300,00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4 454 900,00	9 942 300,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4 454 900,00	9 942 300,00
2200	Дотоод эх үүсвэрээр	4 454 900,00	9 942 300,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4 454 900,00	9 942 300,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4 454 900,00)</u>	<u>(9 942 300,00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.0	00.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.0	00.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	00.0
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	00.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3 214 238 200,00	2 994 937 084,43	219 301 115,57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3 214 238 200,00	2 994 937 084,43	219 301 115,57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 911 298 300,00	2 742 287 356,43	169 010 943,57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2 302 464 300,00	2 209 621 887,32	92 842 412,68
210101	Үндсэн цалин	1 125 082 000,00	1 261 005 630,32	(135 923 630,32)
210102	Нэмэгдэл	1 012 680 500,00	948 616 257,00	64 064 243,00
210104	Урамшуулал	164 701 800,00	00,00	164 701 800,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	313 161 600,00	280 255 079,11	32 906 520,89
210201	Тэтгэврийн даатгал	216 773 000,00	200 804 599,10	15 968 400,90
210202	Тэтгэмжийн даатгал	24 097 200,00	22 129 379,38	1 967 820,62
210203	ҮОМШӨ-ний даатгал	19 277 700,00	17 378 052,35	1 899 647,65
210204	Ажилгүйдлийн даатгал	4 819 400,00	3 616 327,78	1 203 072,22
210205	Эрүүл мэндийн даатгал	48 194 300,00	36 326 720,50	11 867 579,50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110 115 600,00	110 115 600,00	
210301	Гэрэл, цахилгаан	29 040 000,00	17 797 870,80	11 242 129,20
210302	Түлш, халаалт	50 720 400,00	46 721 615,20	3 998 784,80
210303	Цэвэр, бохир ус	30 355 200,00	45 596 114,00	(15 240 914,00)
2104	Хангамж, бараа материалын зардал	34 158 000,00	32 705 580,00	1 452 420,00
210401	Бичиг хэрэг	3 948 500,00	4 162 000,00	(213 500,00)
210402	Тээвэр, шатахуун	5 291 900,00	2 273 500,00	3 018 400,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 234 400,00	3 137 850,00	96 550,00
210404	Ном, хэвлэл	2 827 200,00	2 251 300,00	575 900,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4 105 200,00	4 105 200,00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14 750 800,00	16 775 730,00	(2 024 930,00)
2105	Нормативт зардал	70 171 400,00	29 145 534,00	41 025 866,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7 070 600,00	7 060 960,00	9 640,00
210502	Хоол, хүнс	57 941 400,00	16 925 174,00	41 016 226,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5 159 400,00	5 159 400,00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22 304 000,00	22 160 186,00	143 814,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9 184 000,00	9 180 700,00	3 300,00
210604	Урсгал засвар	13 120 000,00	12 979 486,00	140 514,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41 170 400,00	40 566 150,00	604 250,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37 514 300,00	37 514 300,00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 000 000,00	1 000 000,00	

210803	Даатгалын үйлчилгээ	00,00	321 700,00	(321 700,00)
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393 600,00	194 500,00	199 100,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	393 600,00	87 000,00	306 600,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1 868 900,00	1 448 650,00	420 250,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17753000,00	17717340,00	35 660,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7 458 600,00	7 423 600,00	35 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10 294 400,00	10 293 740,00	660,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	302939900,00	252649728,00	50 290 172,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	302 939 900,00	252 649 728,00	50 290 172,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82 246 200,00	31 982 828,00	50 263 372,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	216 785 700,00	216 785 700,00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3 908 000,00	3 881 200,00	26 800,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3 214 238 200,00	2 994 937 084,43	219 301 115,57
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3 214 238 200,00	2 994 937 084,43	219 301 115,57,
131001	Улсын төсвөөс санхүүжих	3 214 238 200,00	2 994 937 084,43	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	150	140	10
620001	Удирдах ажилтан	01	01	
620002	Гүйцэтгэх ажилтан	88	78	10
620003	Үйлчлэх ажилтан	61	61	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3 135 367,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		835 367,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		835 367,00
2104	Хангамж, бараа материалын зардал		835 367,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		835 367,00
213303	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		2 300 000,0
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3 135 367,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2 300 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатын төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		835 367,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2 300 000,00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		00.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана гэж заасны дагуу дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулах, бэлтгэн нийлүүлэгчдийн төлбөрийн цахим баримтыг хянах, худалдан авалтын гэрээний хэрэгжилтийг хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 15-наас 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд Пийк Ом Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Б.Жаргалсайхан, чанарын хяналтын менежер Б.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль нь сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай боловсролын үйл ажиллагаа явуулдаг БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан бөгөөд тайлант хугацаанд дотоод аудитын хяналт шалгалт хийгдээгүй тул дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,144.654.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 31,446.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж материаллаг байдлын суурь үзүүлэлт болох нийт зардал өмнөх оноос өссөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,374,088.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 33,740.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,540.5 мянган төгрөгөөр буурсан, материаллаг өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	91,747.1	118,479.4	26,732.3
Үндсэн хөрөнгө	4,726,755.3	4,678,927.4	(47,827.9)
Нийт хөрөнгө	4,818,502.3	4,797,406.8	(21,095.5)
Өр төлбөр	00.0	5,445.0	5,445.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,818,502.3	4,791,961.8	(26,540.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,818,502.3	4,797,406.8	(26,540.5)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын данс өссөн нь үдийн цай хөтөлбөрийн 8,125.6 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй, Сүхбаатар дүүргийн боловсролын хэлтэсээс сургалтын хэрэглэгдэхүүнд 19,043.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн;

- Үндсэн хөрөнгө данс нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 9,942.3 мянган төгрөгийн ном, тавилга, хандив тусламжийн эх үүсвэрээр 109,650.6 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном хэрэгсэлийг бүртгэсэн, данснаас хөрөнгө хасагдаагүй;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 5,445.0 мянган төгрөг нь дулааны өглөг байна;

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 3,447,834.0 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 3,447,834.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэнийг 3,447,834.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор цах тахлын улмаас хөл хориотой холбоотой үдийн цай, хоолны зардлыг 233,595.8 төгрөгөөр бууруулж 3,214,238.2 мянган төгрөгөөр баталж, төсвийг нэмж тодотгоогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Тусгай хэрэгцээт боловсролын 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд 3,214,238.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,214,238.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,994,937.1 мянган төгрөгийг зарцуулж 219,301.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,994.937.1 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 125,748.9 мянган төгрөг, хоол хүнсний зардал 41,016.2 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмжийн зардал 50,263.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь батлагдсан орон тооноос 10 орон тоогоор дутуу ажилласан, цар тахлын улмаас дотуур байрны хоол хүнс, үдийн цай хөтөлбөрийн арга хэмжээний зардлуудыг дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71807	Тусгай хэрэгцээт боловсрол	3,214,238.2	2,994,937.1	219,301.1	93.2
1.1	80104	Үйл ажиллагааны урсгал зардал	2,911,298.3	2,742,287.4	169,010.9	94.2
1.2	80802	Урсгал шилжүүлэг	302,939.9	252,649.7	50,290.2	83.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтын дансаар өмнөх онд өмгөөлөгчтэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний үүргийн биелэлт хангагдаагүйн улмаас 2,300.0 мянган төгрөг, Сүхбаатар дүүргээс ариутгал халдваргүйжүүлэлтийн санхүүжилт 835.3 мянган төгрөг нийт 3,135.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, 835.3 мянган төгрөгийг зарцуулж 2,300.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сургуулийн захирал 2021 оны 5 сард ажлаас чөлөөлөгдөж сургалтын менежер захирлын үүргийг хавсран гүйцэтгэж, тайлант онд үр дүнгийн гэрээ байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд тусгай хэрэгцээт боловсролыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний хэрэгжилт 86.9 хувь, батлагдсан төсвийн 93.2 хувийг гүйцэтгэлээр зарцуулсан тул зөрүү 6.3 хувь нь хэрэгжээгүй үйл ажиллагаанд зарцуулагдсан 202,497.0 мянган төгрөг байна.

3.8 Аудитын гол асуудал

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль нь нийт 2,994,937.1 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хугацаа хоцроосон 38,385.4 мянган төгрөгийн 15 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 21,119.1 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илрүүлснээс 3,803.9 мянган төгрөгийн алдааг залруулах, 17,315.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн аудитаар дахин хянахад хэрэгжүүлж ажиллаагүй байна

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 233,454.4 мянган төгрөгийн 3 албан шаардлагын биелэлт 67 хувь, 2,475.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	233,454.4	2	233,454.4	1		33
Зөвлөмж	3	2,475.1	3	2,475.1			100
Нийт дүн	6	235,929.5	5	235,929.5	1	00.0	67

Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэж байх гэсэн 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 173,251.6 мянган төгрөгийн 15 алдаа зөрчил илэрснээс, 36,328.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 5,848.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 119,943.2 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 11,131.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 136,922.9 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 33,740.8 мянган төгрөгөөс 103,182.1 мянган төгрөгөөр их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалыг буруу ангилж бүртгэсэн 3,912.4 мянган төгрөг;
2. бараа материалын нэр төрлөөр нь бүртгээгүй 13,373.3 мянган төгрөг;
3. Бараа материалын тодруулга тайлангийн орлогын дүн 19,043.0 мянган төгрөгөөр бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээс зөрүүтэй.

4.2 Төлбөрийн акт

1. Улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 3 ажилтанд 2,148.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон байгаа нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Дотуур байрны хоолны зардлаас 584.2 мянган төгрөг, эмийн зардлаас 153.7 мянган төгрөг нийт 737.9 мянган төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа 2 ширхэг 2,962.2 мянган төгрөгийн зөөврийн компьютер бодитоор байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “ Үнэн зөв байх” 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

1. Байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай биш зүйлсийг бэлтгэсэн, зах зээлийн үнээс өндөр үнэтэй худалдан авалт хийсэн зэрэг нийт 4,751.0 мянган төгрөгийн төсвийг хэмнэлтэй үр ашигтай зарцуулаагүй байгаа нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй

шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хэмнэлтэй үр ашигтай зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх

2. Ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүгчийн захирамжаар 15,257.6 мянган төгрөгийн цалинг нөхөн олгосон байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинд нөхөн олгосон 15,257.6 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх, авлагаар бүртгэх, албан шаардлага хүргүүлэх.

3. Үдийн цай болон дотуур байрны хоолны зардлыг хооронд нь 11,089.7 мянган төгрөгөөр гүйлгэн зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй ажиллах, албан шаардлага хүргүүлэх.

4. Төсвийг зөв, зохистой удирдаагүйгээс 5,444.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зөв, зохистой удирдаж өр, төлбөр үүсгэхгүй ажиллах, албан шаардлага хүргүүлэх.

5. Цалин, нэмэгдэл, үр дүнгийн урамшууллаас гадна бүх ажилчдад 83,400.0 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдааг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүнсний материалын тайланд үдийн цай болон дотуур байрны хоолны зарцуулалтын тайлан засвартай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэн, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

2. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын бүртгэлд үндсэн хөрөнгийн шинжтэй 10,193.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг хэрэгжүүлэн, бараа материалыг үнэн зөв ангилж бүртгэл хөтлөх.

3. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд 841.4 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэн ажиллаж, цаашид сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд үр дүнгийн урамшуулал олгохгүй байх.

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүнсний материалын үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 97.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Илүү байгаа хүнсний материалыг данс бүртгэлд тусгах, дутсан материалыг эд хариуцагчаар төлүүлж, цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэн бараа материалын бүртгэлийг үнэн зөв хөтөлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Бараа материалыг буруу ангилж бүртгэсэн 3,912.4 мянган төгрөг	1	3,912.4	1	3,912,4								
2	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Бараа материалыг нэр төрлөөр бүртгээгүй 13,373.3 мянган төгрөг байна.	1	13,373.3	1	13,373,3								
3	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Бараа материалын тодруулга тайлангийн орлогын дүн 19,043.0 мянган төгрөгөөр бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээс зөрүүтэй байна.	1	19,043.0	1	19,043.0								
3	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 3 ажилтанд 2,148.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	2,148.1			1	2,148.1						
4	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Дотуур байрны хоолны зардлаас 584.2 мянган төгрөг, эмийн зардлаас 153.7 мянган төгрөг нийт 737.9 мянган төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан байна.	1	737.9			1	737,9						

5	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Үндсэн дансанд байгаа 2 мянган зөврийн бодитоор байна. хөрөнгийн бүртгэлтэй ширхэг 2,962.2 төгрөгийн компьютер байхгүй байна.	1	2,962.2				1	2,962.2						
6	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Олон цаг асдаг, анхилам үнэртэй ашигтай бактери зэрэг зайлшгүй шаардлагатай биш зүйлсийг бэлтгэсэн, 115,0-220,0 мянган төгрөгийн үнэтэй гар бөмбөг, сагсан бөмбөг болон үхэр, хонины махнаас өндөр үнэтэй тахианы мах худалдан авч нийт 4,751.0 мянган төгрөгийн төсвийг хэмнэлтэй үр дүнтэй зарцуулаагүй байна.	1	4,751.0				1	4,751.0						
7	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүгчийн захирамжаар 15,257.6 мянган төгрөгийн цалинг тайлант оны цалингийн зардлаас нөхөн олгосон байна.	1	15,257.6				1	15,257.6						
8	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Үдийн цай болон дотуур байрны хоолны зардлыг 11,089.7 мянган төгрөгөөр гүйлгэн зарцуулсан байна.	1	11,089.7				1	11,089.7						
9	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Төсвийг зөв, зохистой удирдаагүйгээс 5,444.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.	1	5,444.9				1	5,444.9						

10	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Цалингийн зардлаас цалин, нэмэгдэл, үр дүнгийн урамшууллаас гадна бүх ажилчдад 84,600.0 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон байна.	1	83,400.0					1	83,40.0.0				
11	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Хүнсний материалын тайланд үдийн цай болон дотуур байрны хоолны зарцуулалтын тайлан засвартай байна.	1										1	
12	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Бараа материалын бүртгэлд үндсэн хөрөнгийн шинжтэй 10,193.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг бүртгэсэн байна.	1	10,193.0									1	10,193.0
13	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд 841.4 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	841.4									1	841.4
14	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Хүнсний материалын үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 97.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	97.1									1	97.1
Дүн				15	173,251.6	3	36,328.7	3	5,848.2	5	119,943.2			4	11,131.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
1	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль	АХГ-2022/42/Н А-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим системд мэдээллээ хугацаанд нь байршуулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 38,385.4 мянган төгрөгийн 15 мэдээллийг хугацаа	1	38,385.4					1	38,385.4	1	38,385.4		

			хоцроож байна.	мэдээлсэн											
Дүн				1	38,385.4					1		1	38,385.4		
Нийт дүн				16	211,637.0	3	36,328.7	3	5,848.2	5	158,327.6	1	38,385.4	4	11,131.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 41/20150058

Улаанбаатар хот

АХГ-2020/42/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийг зөв, зохистой удирдаагүйгээс 5,444.986 төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалсагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өглөгийн барагдуулах зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Ундрал, нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 40/20150058

Улаанбаатар хот

АХГ-2022/42/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үдийн цай болон дотуур байрны хоолны зардлыг хооронд нь 11,089.700 төгрөгөөр гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалсагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үдийн цай болон хоолны зардлын гүйцэтгэлийг гаргаж, 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Ундрал, нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
А.МӨНХЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 39/20150058

Улаанбаатар хот

АХГ-2022/42/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай биш зүйлсийг бэлтгэсэн, зах зээлийн үнээс өндөр үнэтэй худалдан авалт хийсэн зэрэг нийт 4,751.000 төгрөгийн төсвийг хэмнэлтэй, үр ашигтай зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Ундрал, нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ
Б СЭРЖМЯДАГ
А МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 38/АД/50058

Улаанбаатар хот

АХГ-2022/42/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар 15,257,600 төгрөгийн цалинг нөхөн олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагаар тусгаж, буруутай албан тушаалтаар төлүүлж зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Ундрал, нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
А.МӨНХЦЭЦЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-40.Docx

001081655



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 12/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/42/МА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа 2,962.200 төгрөгийн зөөврийн 2 ширхэг компьютер бодитоор байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх” гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль компьютерийн үнэ 2,962,200 /Хоёр сая есөн зуун жаран хоёр мянга хоёр зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Ундрал, нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264210

\\10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 2 Gazar-11.Docx

001030046



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 11/АД/150058

Улаанбаатар хот

АХГ-2022/48/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн 3 ажилтанд улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2,148,144 төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн илүү олгосон 2,148,144 /Хоёр сая нэг зуун дөчин найман мянга нэг зуун дөчин дөрвөн/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Ундрал, нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

А.МӨНХЦЭЦЭГ

4006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10\Bichig_Kherig\Akt\2022\0225 Auditin 2 Gazar-10.Docx

001090043



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 10/АО/50058
АХГ-2022/42/НА-СТА-ОМЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотуур байрны хоолны зардлаас 584.200 төгрөг, эмийн зардлаас 153.713 төгрөг нийт 737.913 төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй ба Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль зориулалт бусаар зарцуулсан 737,913 /Долоон зуун гучин долоон мянга есөн зуун арван гурван / төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг сургуулийн захирал захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Ундрал, нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
А.МӨНХЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 259/А0150058
АХГ-2022/42/НБ-СТБ-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалин, нэмэгдэл, үр дүнгийн урамшууллаас гадна бүх ажилчдад 83,400.000.00 төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол улсын засгийн газрын 2019 оын 5 дугаар тогтоолын Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 4 дүгээр хавсралтын 4.5. "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Ундрал, нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 42/20150058

Улаанбаатар хот

АХГ-2022/40/МА-СТА-ТЦЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд нийт 2,994,937.1 мянган төгрөгийн гүйлгээний мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хугацаа хоцроосон 38,385,391 төгрөгийн 15 гүйлгээний мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн ШААРДАХ нь гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн ахлах нягтлан бодогч Л.Мөнхгэрэлд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Ундрал, нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shoordlaga\2022\0225 Auditin 2 Gazar-44.Docx

001081667

